ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМТЭН, СУДЛААЧИДТАЙ УУЛЗЛАА 2

“ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨӨЧ ОЮУТАН” ӨДӨРЛӨГ БОЛЛОО 3

ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2024 ӨДӨРЛӨГ БОЛЛОО 5

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Баталсан хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг төр л хамгийн тогтвортой оршдог.*

*Аристотель*

# ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

www.nli.gov.mn Цахим сонин 2024.02.29

## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМТЭН, СУДЛААЧИДТАЙ УУЛЗЛАА

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр өнөөдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд ажиллаж, судлаачидтай уулзлаа.

Уулзалтын эхэнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах байгууллагын үйл ажиллагаа, хууль зүйн сургалт, судалгааны чиглэлээр хийж буй онцлох ажлуудаа танилцуулав.

ХЗДХ-ийн сайд Б.Энхбаяр сайн хууль бий болох суурийг тавьж өгдөг хүмүүс бол эрдэмтэн судлаачид. Хууль зүйн бодлогыг оновчтой, хөрсөнд буусан, амьдралд нийцсэн, олонургальч, хүний эрхийн мэдрэмжтэй байдлаар тодорхойлоход Хууль зүйн үндэсний хүрээлэн чухал нөлөөтэйг онцолсон юм.

*Үргэлжлэл 2 дугаар нүүрт*




ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшнл трэйд тауэр барилгын 9 давхар, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Ц.Энхжин

... өмнөх нүүрт

Нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм, журмууд шинжлэх ухаанч, судалгаан дээр суурилсан байх нь хожим алдаа мадаг гарахаас урьдчилан сэргийлдэг гэдгийг тодотгов. Түүнчлэн залуу судлаачдад хандан “Нийгэмдээ гэрэл асаах маш үнэ цэнтэй ажил хийж буйгаа ухамсарлаж, үргэлж ажлаараа бахархаж яваарай” гэлээ.

Цаашдаа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдыг гадаад оронд туршлага судлах, эзэмшсэн мэргэжлээрээ мерит зарчмаар дэвшин ажиллах, нийгмийн хамгааллын асуудлыг шийдэхэд анхаарч ажиллана гэдгээ энэ үеэр хэлсэн юм. Уулзалтын төгсгөлд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн залуу судлаачидтай хаврын чуулганаар хэлэлцэх хуулийн төслүүд болон хүний эрхийн асуудлаар санаа бодлыг нь сонсож, яриа өрнүүллээ.











## “ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГЧ ОЮУТАН” ӨДӨРЛӨГ БОЛЛОО

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төв, Оюутны хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулж буй “Хууль, эрх зүйн зөвлөгч оюутан” өдөрлөг 2024 оны 04 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд МУИС-ийн Номын сан болон зарим хичээлийн байранд өртөөлөн зохион байгуулаглаа. Өдөрлөгөөр МУИС-ийн оюутан, багш, албан хаагчдад тулгамдсан асуудлаар хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгөв.

Зөвлөгөөг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, “Легал Консалтанси энд Рисерч Тийм” ХХК, “СНОУ ХИЛЛ КОНСАЛТИНСИ” ХХН, “Дэнс легал” ХХК, “Эм Жэй Эл Атторнейс” ХХН гэсэн байгууллагуудын мэргэжлийн хуульчид өглөө. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Захиргааны эрх зүйн асуудлаар Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн магистр (LL.M) Р.Хатансайхан, Иргэний эрх зүйн асуудлаар Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн ажилтан М.Үнэнзаяа тус тус зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.











## “ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БА ХҮНИЙ ЭРХ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран “Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрх” хэлэлцүүлгийг 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг нээж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Э.Энхбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид нар үг хэлэв.

Хэлэлцүүлгээр “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан багц хуулийн төслүүдийн танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний тогтоох эрхийг захиргааны байгууллагад шилжүүлэх заалтын хүрээ хязгаар, хууль, хэм хэмжээний актын харилцан хамаарлыг тодорхойлох онолын харьцуулсан судалгааны танилцуулгыг Судлаач, МУИС-ийн гэрээт дэд профессор, Хууль зүйн доктор Ц.Цогт, Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрхийн зөрчлийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц нар танилцууллаа.

Хэлэлцүүлэгт яамдын Бодлогын газар болон хуулийн хэлтсийн дарга, мэргэжилтэн нар, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагын хуулийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, Монголын хуульчдын холбооны төлөөлөл оролцов.













# ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2024 ӨДӨРЛӨГ БОЛЛОО

Монголын Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчийн Про Боно өдөр-2024” өдөрлөгийг өнөөдөр буюу Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж байна.

Тус өдөрлөгт Хууль зүйн үндэсний хүрээлэн оролцож, үйл ажиллагаагаа танилцуулж, үнэ төлбөргүй эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгч байна.

Мөн өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны бүтцийн байгууллага, гишүүн хуульчдаас гадна Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, , Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Нотариатчдын танхим, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн газар зохион байгуулалтын газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Санхүүгийн зохицуулах хороо, өмгөөллийн “Эм Жи Эл атторнейс”, “Легал гайд” ХХН, МУИС-ийн Практик сургалтын төв, “Шихихутуг” их сургууль зэрэг хуулийн болон төрийн захиргааны байгууллага, өмгөөллийн нөхөрлөлүүд оролцож, үйл ажиллагаагаа танилцуулж, иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгч байгаа бөгөөд зарим байгууллага төрийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүллээ.


















## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯН 2024
























## ОЮУНЫ ӨМЧӨӨ ХУУЛИАР ХАМГААЛУУЛЪЯ










ГАДУУРХАЛТЫН ЭСРЭГ
ЗОГСОЖ Л БАЙВАЛ
ГАНЦААРАА
БАЙСАН Ч
ХАМААГҮЙ
ДЭЭРЭЛХЭЛ
ДЭЛГЭРЭХ
ЁСГҮЙ
# НЭГНЭЭ ГОМДООХ ЗҮЙЛ
БИТГИЙ ХИЙГЭЭРЭЙ